



## ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

# ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖСӨН ТӨРИЙН ДУНД ШАТНЫ АЛБАН ТУШААЛТНУУДЫГ НАРИЙВЧЛАН ШАЛГАНА

*Авлигатай тэмцэх газраас сар бүрийн 25-ны өдөр хэвлэлийн бага хурал зарлаж, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хийсэн ажил, арга хэмжээний талаар мэдээлдэг билээ. Энэ удаа тус газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Т.Баярхүү, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Хяналт шалгалтын албаны дарга, ахлах комиссар Л.Сүх-Очир, Мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Э.Идэрцог нар хэвлэлийн бага хуралд оролцож, мэдээлэл хийв. Тэд мэдээллийн дараа сэтгүүлдийн асуултад хэрхэн хариулсныг дор сийрүүлэв.*



Гэрэл зургийг А.Санжиа

**-Төрийн байгууллагуудыг шалгасан дүнгээ хэзээ танилцуулах вэ? Засгийн газарт зөвлөмж хүргүүлнэ гэж байсан. Зөвлөмжөө хэзээ өгөх вэ? Илэрсэн зөрчлүүдийг яаж шийдвэрлэх вэ? Мэдээлээд өнгөрөх үү? Эрүү үүсгэх үү? Эрүү үүсгэхгүй бол ямар хариуцлага тооцох вэ?**

**З.Баасанням:** -Бид төрийн бүх шатны байгууллагад очиж ажилласан. Өнгөрсөн хавар яам, агентлаг болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд ажилласан. Сая орон нутагт ажиллаад үндсэндээ дуусч байна. Ажилласан дүнгээ нэгтгээд бид Засгийн газарт, салбар хариуцсан сайд нарт, аймгийн Засаг дарга нарт Зөвлөмж хүргүүлнэ. Зөвлөмжөө энэ долоо хоногт хүргүүлсний дараа ямар арга хэмжээ авахаар тусгасан талаараа та бүхэнд мэдээлнэ. Яам, агентлагт ажилласан дүнг бид хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлэгт яригдсан асуудлын мөрөөр зарим яам, агентлагийн түвшинд тодорхой ажил хийгдээд эхэлсэн. Тухайлбал, төрийн сангийн зээлээр суралцсан боловч зээлээ

төлөөгүй иргэдийн нэрсийг зарлаж, зээлийг төлүүлэх арга хэмжээг авах чиглэлээр АТГ-ын өгсөн үүргийг Боловсролын зээлийн сан хэрэгжүүлж ажиллаж байна. Зөвхөн зөвлөмж өгсөн талаар биш уг зөвлөмжийн мөрөөр төрийн байгууллагууд ямар ажил, арга хэмжээ зохион байгуулж ажилласан бэ, дурдсан зөрчлийг хэрхэн арилгасан бэ, ямар хариуцлага тооцсон бэ гэдэг талаарх мэдээллийг бид та бүхэнд бас өгнө. Яг одоогоор төчнөөн эрүүгийн хэрэг үүсгэсэн, шалгасан гэдэг дүгнэлт эцэслэн гараагүй байгаа. Зарим ажлын хэсэг маань орон нутагт ажиллаж дуусаагүй. Тэд ажлаа дуусгаад нэгдсэн тайлан гарсны дараа энэ талаар бүрэн мэдээлэл өгөх боломжтой.

**-Авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас улсад 65.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан гэж сая мэдээллээ. Энэ нь ямар хугацаанд гарсан хэмжээ вэ?**

**Э.Идэрцог:** -2017 оны эхний 11 сарын байдлаарх тоо хэмжээ.

**-Хойд Солонгосоос 300 мянган ам.доллар нэхэмжилсэн бичиг ирсэн,**

**ирээгүй гэж яриа гарч байна. Б.Хурц генерал ийм бичиг ирсэн, АТГ-т шилжүүлсэн гэж байгаа, харин Ц.Нямдорж сайд ирээгүй гэж ярьсан. Энэ асуудал танай дээр байна уу?**

**Э.Идэрцог:** -Энэ удаагийн хэвлэлийн хурал дээр прокурорын байгууллагаас тодорхой хэргийн талаар мэдээлэх зөвшөөрөл өгөөгүй. Тиймээс тодорхой хэргийн талаар ярих боломжгүй. БНАСАУ-аас 300 мянган ам.доллартай холбоотой асуудал АТГ-т ирсэн. Нягтлах, нарийвчлан шалгах ажиллагаа хийгдээд явж байгаа.

**-Энхбат гэдэг хүний ярилцлага гарсан байна лээ. АТГ-т нөлөөлөөд урьдчилсан мэдүүлгийг хянах хугацааг сунгаж байсан гэж ярьсан. Ийм боломж байдаг уу?**

**Л.Сүх-Очир:** -Энхбат гэж ямар хүн юм бол, би сайн мэдэхгүй байна. АТГ хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг ажлын 10 хоногт хянаж хариуг хүргүүлдэг.

Төгсгөл нь III нүүрт

## МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

# Нийслэлийн төрийн байгууллагуудад ажилласан дүнг хэлэлцүүлэв

**Нийслэлийн Засаг даргын Тамгын газар.** Авлигатай тэмцэх газрын Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албаны дарга, ахлах комиссар Т.Төгөлдөрийн ахалсан ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд ажиллах явцдаа хүний нөөц, боловсон хүчний томилгоо, төрийн үйлчилгээ, удирдлагаас батлан хэрэгжүүлж буй дүрэм журам, тушаал шийдвэр, төлбөр хураамж, тендер сонгон шалгаруулалт, худалдан авах ажиллагаа, тусгай зөвшөөрөл олгох үйл явц зэрэгтэй танилцаж, дүгнэлт гаргажээ. Ийнхүү ажиллах явцад дараах хэд хэдэн нийтлэг зөрчил, дутагдал илэрчээ. Тухайлбал, нийт удирдах албан тушаалтны 50 хувь нь шинээр томилогдсон нь боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчимд тулгуурлан томилох зарчим алдагдсан, сонгуулийн үр дүн, нам, улс төрийн нөлөөтэй гэж үзэхээр байна.

Худалдан авах ажиллагааны хувьд, батлагдсан зураг төсөвгүй, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй /техникийн нөхцөл, газар олголт гэх мэт/ зэрэг бэлтгэл ажил хангагдаагүй ажлыг төлөвлөгөөнд тусгадгаас үүдэн тендер зарлах явц удаашралтай, төлөвлөгөө тасрах явдал гарч байгааг цаашид анхаарах шаардлагатай гэж Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгээс анхааруулав.

**Нийслэлийн агентлагууд.** Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяа 15 агентлагт очиж ажилласан дүнгээ 2017 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр “Олон нийтийн төв”-д тэдгээр агентлагийн удирдах албан тушаалтнуудыг оролцуулан хэлэлцүүлээ.

Ажлын хэсэг ажиллах явцад нийслэлийн агентлагуудад төрийн үйлчилгээ нь олон шат дамжлага, хүнд суртал, чирэгдэл ихтэй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй, эрх зүйн зохицуулалтгүй, хуулиар олгогдоогүй эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхээ хэтрүүлсэн шийдвэр гаргах, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, мэдээллийн ил тод байдал хангалтгүй зэрэг нийтлэг зөрчил, дутагдал илэрчээ. Тухайлбал, газар өмчлүүлэх, ашиглуулах гэрчилгээ авах, сунгуулахад 60-аас дээш хоногийн дараа шийдвэр гаргадаг байна. Гэтэл Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т “Аймаг,

нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор эрхийн гэрчилгээ эзэмших нөхцөлийг хангаж ажилласан эсэхийг хянаж, түүнийг хангасан тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах шийдвэр гаргана” гэж заасан байдаг. Тиймээс Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг энэ асуудлаар оновчтой зохицуулалт хийж, механизмыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

**Нийслэлийн дүүргүүд.** Авлигатай тэмцэх газрын даргын баталсан удирдамжийн дагуу тус газрын ажлын хэсгүүд нийслэлийн Багануур, Багахангай, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн 2015, 2016, 2017 оны эхний улиралд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн ажил байдалтай танилцсан дүнгээ хэлэлцүүлээ.

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3-т “энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэсэн заалтыг зөрчиж хөрөнгийг зарцуулсан байна. Тухайлбал, Багахангай дүүрэг “Шинэ жилийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 4.6 сая төгрөг, “Санхүү, эдийн засгийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан шагнахад 5.1 сая төгрөг, Баянзүрх дүүрэг волейболын тэмцээнд амжилттай оролцсон тамирчдыг урамшуулахад 1.7 сая төгрөг, сагсан бөмбөгийн лигийн тэмцээн зохион байгуулахад 27.3 сая төгрөг, Чингэлтэй дүүрэг шагнал, урамшуулалд 132 сая төгрөг гэх мэтээр Засаг даргын нөөц хөрөнгийг шагнал урамшуулал, баяр наадам, тэмцээн уралдааныг зохион байгуулахад зарцуулж байгаа нь Авлигатай тэмцэх газрын анхаарлыг татаж байна. Тиймээс Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3-т заасан “Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх” гэснийг цаашид нарийвчлан тодорхойлох, өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэх, өөрчлөн засах шаардлагатай гэж Авлигатай тэмцэх газар үзэж, энэ талаар холбогдох саналыг уламжлахаар бэлтгэж байна.

## Ажлын хэсгийн хоёр дахь ээлж орон нутагт ажиллалаа

Авлигатай тэмцэх газрын орон нутагт ажиллах ажлын хэсгийн хоёр дахь ээлж 2017 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр замд гарлаа.

Авлигатай тэмцэх газрын хэлтэс, албадын дарга нараар ахлуулсан ажлын хэсгийн эхний ээлж 2017 оны 10 дугаар сарын 29-нөөс эхлэн 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд Ховд, Баян-Өлгий, Увс, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт ажиллаад ирэв. Ажлын хэсгийн хоёр дахь ээлж 2017 оны 11 дүгээр сарын 12-24-ний өдрүүдэд Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Орхон аймагт ажиллана.

Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Хашбаатар, Мөрдөн шалгах хэлтсийн Мөрдөн байцаах албаны дарга, ахлах комиссар Н.Дамдинсүрэн, Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албаны дарга, ахлах комиссар Т.Төгөлдөр нараар ахлуулсан ажлын хэсэг орон нутагт ажиллахдаа аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд ажиллах “Авлигаас урьдчилан сэргийлэх Олон нийтийн дэд зөвлөл”-ийн гишүүдтэй гэрээ байгуулж, үйлжиллагааг нэхлүүлэх, орон нутгийн төрийн байгууллагуудын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг газар дээр нь шалган туслах, авлигын нөхцөл байдлыг тодорхойлох юм.

Түүнчлэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, үйл ажиллагаа, баримт, материал, хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, албан тушаалын томилгоо, төрийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал, тухайн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн тоо, тэдгээрийн агуулга, шийдвэрлэлт, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн албан бичиг, мөрдөн байцаагчийн мэдэгдэл, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцаж судлан, санал дүгнэлт боловсруулав.

## ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

### Төгсгөл. Түүрүүч нь I нүүрт

Үүнтэй холбоотой өргөдөл, гомдол шалгуулахаар ирүүлдэг болсон. Хяналт шалгалтын журмын дагуу бид шалгаад тухайн газарт хариуг нь хүргүүлдэг. Ашиг сонирхлын зөрчилтэй бол зөрчилтэй гээд, зөрчилгүй бол зөрчилгүй байна гэсэн хариуг өгдөг. Шалгах хугацаандаа үүнтэй холбоотой өргөдөл, гомдол ирүүллээ, энэ хүний асуудлыг үзэж харж байна гэдэг байдлаар эхний ээлжинд албан бичгийг тухайн газарт хүргүүлдэг. Дараа нь гаргасан шийдвэрээ хүргүүлдэг. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянах хугацааг сунгана гэсэн ойлголт байхгүй.

**-Орон нутагт Олон нийтийн**

ажиллаж байгаа. Тэд тухайн төрийн байгууллагын удирдлагаас батлан гаргасан тушаал шийдвэр нь ашиг сонирхлын зөрчилтэй юу, төсөв мөнгөний зарцуулалт нь ямар вэ, шилэн дансанд зохих мэдээллүүдийг тавьж байна уу, худалдан авах ажиллагаанд хамаарал бүхий этгээдээ оролцуулж тэдэндээ давуу байдал олгож байна уу, хөрөнгө орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлж байна уу гэх мэтээр төрийн байгууллага, төрийн албан тушаалтны үйл ажиллагааг иргэдийн хяналтад өгөх ажил юм. Энэ ажил дөнгөж эхэлж байгаа. Олон нийтийн хяналтын үйл ажиллагаа эдгээр иргэд дээр төвлөрч явагдана гэж ойлгож болно.

**-Авто тээврийн үндэсний төвийн дарга нар, Нийслэлийн**

ярьсан. Та бүхнийг орон нутагт ажиллаж байхад нийм төрлийн зөрчил хэр зэрэг илэрсэн бэ? Энэ тал дээр тодорхой ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

**Т.Баярхүү:** -Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга Серикжантай холбоотой асуудлаар манай ажлын хэсэг ажиллах явцад нэгэн иргэн уулзсан. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах тухай хуульд заасны дагуу албан ёсоор бидэнд өргөдөл өгөөгүй. Энэ хүн өөрөө мэдээлэлд дурдагдаад байгаа мөнгө төгрөг өгсөн гэдэг асуудлын талаар мэдэхгүй гэсэн. Тухайн асуудлыг мэдэж байгаа гэх нэр бүхий хүмүүс нь бидэнд олдоогүй. Харин уулзсан хүн зарим асуудлыг тодруулаад эргэж

Анхбаярын “Эрдэнэт” үйлдвэрт шахаа хийсэн гэх мэдээлэл бас бий. УИХ-ын гишүүн Ж.Батзандангийн хоёр ахыг шалгасан гэж байгаа. Энэ үнэн үү?

**Э.Идэрцог:** -Тодорхой хэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүйг дахин сануулъя. Ц.Нямдорж сайдын хүүг “Эрдэнэт” үйлдвэрт бараа бүтээгдэхүүн шахсан гэдэг асуудал шалгагдаагүй. 4 дүгээр цахилгаан станцын дарга Анхбаяр нь “Эрдэнэт” үйлдвэрт бараа шахсан гэх утгатай гомдлыг хүлээн авч шалгасан. Нэр дурдагдсан Анхбаяр гэдэг нэртэй хүн гэрээ байгуулж “Эрдэнэт” үйлдвэрт бараа материал нийлүүлсэн гэх асуудал тогтоогдоогүй. Энэ асуудлыг Мөрдөн шалгах хэлтэс

# ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖСӨН ТӨРИЙН ДУНД ШАТНЫ АЛБАН ТУШААЛТНУУДЫГ НАРИЙВЧЛАН ШАЛГАНА

дэд зөвлөлийг байгуулж байна гэж ярилаа. 3 иргэн ажиллуулж байгаа гэсэн. Яаж сонгон шалгаруулж байгаа вэ? АТГ-ын дэргэдэх Г.Баасан даргатай Олон нийтийн зөвлөлтэй ямар хамааралтай вэ?

**З.Баасаньям:** -Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт зааснаар орон нутаг дахь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор зөвлөл байгуулан ажиллана гэж байгаа. Энэ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Авлигатай тэмцэх газрын даргын хамтарсан тушаалаар баталсан журам үйлчилж байгаа. Үүний дагуу аймаг бүрт авлигаас урьдчилан сэргийлэх Олон нийтийн дэд зөвлөл ажиллаж эхэлсэн. Энэ нь манай дэргэд ажиллаж байгаа Г.Баасан даргатай Олон нийтийн зөвлөлтэй хамааралгүй. Олон нийтийн дэд зөвлөлийн үйл ажиллагаа Олон нийтийн зөвлөлөөс тусдаа явагдана. Дэд зөвлөлийн гишүүдээр сонгогдсон 3 иргэн АТГ-тай гэрээ байгуулан

Нийтлэг үйлчилгээний газрын дарга нарыг шалгаж байгаа. Энэ хэргийн талаар мэдээлэх боломжтой юу?

**Э.Идэрцог:** -Мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа. Зам тээврийн яамны албан тушаалтнууд болон Авто тээврийн үндэсний төвийн бусад албан тушаалтууд оролцсон эсэх, өөр үйлдэл, холбогдол байгаа эсэхийг нарийвчлан шалгана. Цогцоор нь авч үзэх шаардлагатай. Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын нэр бүхий албан тушаалтнуудын хувьд албан тушаалаа урвуулан ашиглаж төсвийн хөрөнгө хувьдаа завшсан асуудлаар шалгагдаж байгаа. Одоогоор тэдний учруулсан хохирлын хэмжээ гэхэд тэрбум гаруй төгрөгийн асуудал болоод байна. Ер нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн төрийн дунд шатны албан тушаалтнуудыг цаашид нарийвчлан шалгана.

**-Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга хүмүүсээс хахууль авч хүлээлгэнд оруулсан тухай мэдээлэл манай сайт дээр гарсан. АТГ-т аудио зэрэг тодорхой баримт явуулаад байхад шалгахгүй байна гэж**

холбогдоно гээд дахин уулзаагүй, өргөдөл гаргаж хандаагүй байна.

**-Булган аймгийн шүүхийн ерөнхий шүүгчтэй холбоотой асуудал үүсээд байгаа. Авлига авсан талаар танайд хандсан. Энэ асуудлыг шалгаж байгаа юу?**

**Л.Сүх-Очир:** -Булган аймгийн шүүхийн байгууллагатай холбоотой асуудлыг манай ажилтан шалгаж байгаа. Ёс зүйтэй холбоотой асуудал нь Шүүхийн ерөнхий зөвлөл дээр шалгагдаж байгаа юм билээ. Манайд хандсан өргөдлийн агуулга нь ёс зүйтэй холбоотой байсан. Авлигатай холбоотой асуудал өргөдөлд байгаагүй. Тиймээс харьяаллын дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл рүү шилжүүлнэ. Гомдол гаргасан иргэн хөрөнгө, орлогын мэдүүлгийн асуудлаар манайд дахин хандсан. Энэ асуудлыг нягтлан үзэж байгаа. Өргөдлийг дөнгөж хүлээн аваад байна.

**-4 дүгээр цахилгаан станцын дарга Анхбаяр 4,0 сая ам.долларын гэрээг “Эрдэнэт” рүү шахсан. Үүнд Ц.Нямдорж нөлөөлсөн гэсэн мэдээлэл байгаа. Энэ хэргийг танайх шалгаж байгаа юу? Ц.Нямдоржийн хүү**

өргөдөл, гомдол хүлээн авч шалгаад хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлсэн. УИХ-ын гишүүн Ж.Батзандангийн хоёр ахтай холбоотой асуудлыг тус хэлтэст 2015, 2016 онд тус тус шалгагдаж, аль алиныг нь прокурор хэрэгсэхгүй болгож шийдвэрлэгдсэн.

**-Төмөр замын хэрэгт хэчнээн хүн шалгагдаж байгаа вэ? Интерполоор хэчнээн хүн эрэн сурвалжлагдаж байна вэ?**

**Э.Идэрцог:** -Мөрдөн байцаах ажиллагаа явагдаж байгаа. Өмнө нь та бүхэнд прокурорын зөвшөөрөлтэйгээр мэдээлэл өгч байсан. Одоо бол мэдээлэх боломжгүй. Тухайн үедээ хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийн дагуу хамтарсан ажлын хэсгээс 2 хүнийг интерполоор зарлаж хайлгаж байсан.

**-Авто тээврийн үндэсний төвийн дарга Батбаяр гэдэг хүн Өмнөговийн нэг хүнээс 20 сая төгрөг авч байгаад үйлдэл дээрээ баригдсан гэж мэдээлэгдэж байгаа. Энэ үнэн үү?**

**Э.Идэрцог:** -Энэ асуудал шалгагдаж байгаа. Шалгалтын ажил явж байгаа учраас мэдээлэл өгөх боломжгүй.





*АТГ-ын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасаннямтай цаг үеийн асуудлаар ярилцлаа.*

**-Хоёулаа сүүлийн үед АТГ-тай холбоотой асуудлаар ярилцлагаа эхлүүлье. Үнэхээр АТГ, Олон нийтийн зөвлөлийн дарга Г.Баасанг шалгаж байгаа юм уу?**

-АТГ-т иргэнээс гомдол мэдээлэл ирсэн юм билээ. Урьд өмнө эрхэлж байсан ажил албатай нь холбоотой асуудлаар гомдол мэдээлэл ирсэн. Мэдээллийг хянан шалгаж шийдвэрлэх ёстой. Манай ОНЗ-ийн дарга юм шүү гээд ирсэн гомдлыг хав дараад өнгөрвөл жинхэнэ хууль завхруулсан явдал болно. Прокурорын хяналтад байцаан шийтгэх ажиллагаа явагдаж байгаа болохоор гомдол мэдээлэлд ямар асуудлыг шалгуулахаар ирүүлсэн байгаа талаар мэдээлэл өгөх боломжгүй юм. Авлигатай тэмцэх газрыг шүүмжилснийх нь төлөө ч гэдэг юм уу Баасан даргыг зориуд шалгаж байгаа асуудал байхгүй. Олон нийтийн зөвлөлийн дарга биш байсан ч энэ өргөдөл гомдол нь шалгагдахаар ирэх л байсан байлгүй дээ.

**-Тэгвэл Г.Баасан гуай АТГ-ын үйл ажиллагааг шүүмжилсэн. Үүнээс болж намайг шалгаж байна гэх утгатай мэдээлэл хийсэн шүү дээ?**

-Г.Баасан гуай сүүлд хийлгэсэн хэвлэлийн хурлаараа АТГ-ын үйл ажиллагааны талаар үндэслэлгүй, баримтгүй, судалгаагүй зүйл ярьсан байна лээ. Түүний ярьсныг бид шүүмжлэл гэж ойлгохгүй байгаа. Аливаа нэг улс төрийн зорилгогүй, үнэн зөв үндэслэлтэй, ажилд хэрэгтэй эрүүл шүүмжлэлийг бол хүлээн зөвшөөрнө, бүрэн хүлээн авна.

**-Танай үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж байгаагаа мэдэгдэл зөвлөмж гаргаснаа сэтгүүлчдэд танилцуулсан байна лээ. АТГ-т тэр зөвлөмжөө өгсөн биз дээ?**

-Үнэн хэрэгтэй тэр зөвлөмжөө бидэнд одоо хүртэл өгөөгүй байна. Хэнд хандсан

## З.БААСАННЯМ: АТГ гэдэг дайсан илрүүлчихсэн, түүнтэй тэмцье гээд байгааг ойлгохгүй байна

зөвлөмж гэдэг нь ойлгомжгүй. АТГ-ын үйл ажиллагаанд зөвлөж байгаа бол бидэнд зайлшгүй өгөх ёстой байх. Одоогоор ирүүлсэн зүйл алга.

Хэвлэлд гарсан мэдээллийг уншсан. Та тэр асуудалтай холбогдуулан үнэхээр ярилцлага авах гэж байгаа бол миний өгөх хариулт хариу хэрүүл хийж байгаа юм шиг болчих байх, учир нь зөвлөмжид дурдсан асуудлууд нь өөрөө үндэслэлгүй зүйлс байгаа болохоор. Г.Баасан даргатай ОНЗ дур зоргоороо ярьж байна. Хэвлэлд хандаж байгаа асуудлаараа олон нийтэд мэдээлэхээс өмнө бидэнд хандаж, асууж тодруулах нь хэзээд нээлттэй шүү дээ.

**-АТГ шилэн дансны хуулийг хэрэгжүүлдэггүй гэж дүгнэсэн. Үүнд Та ямар тайлбар хэлэх вэ?**

-Ямар ч баримтгүй, үндэслэлгүй яриа. Жирийн иргэн учрыг нь ухаж ойлголгүй өнгөц хараад байгууллагын талаар ийм зүйл ярьжээ гэвэл бас ойлгож болох юм. Харин хуульч хүн, тэр тусмаа олон нийтэд танигдсан хүн өөрөө үзэж харж танилцсан мөртлөө нийгмийн сэтгэл зүйд сөрөг нөлөөтэй, буруу ташаа мэдээллийг зориуд тараана гэдэг бол байж болохгүй л асуудал. АТГ төсөв санхүүгийн мэдээллээ өөрийн цахим хуудсандаа, шилэн дансны цэсэндээ сар тутмаар хуулийн хүрээнд шаардлагатай бүхий л мэдээллийг байнга байршуулж байгаа. Хүссэн хүн нь хэзээ дуртай цагтаа ороод үзэж болно. Нээлттэй байдаг. Тэнд төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон бусад мэдээллүүд сар бүр нэмэгдэж, шинэчлэгдэж ордог. Хамгийн сүүлд 10 дугаар сарын мэдээлэл нь орсон байгаа. Бас “Ил тод байдал” гээд тусдаа үндсэн цэс байгаа. Энд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллүүдийг мөн сар, улирал тутмаар байршуулсан байгаа. Төлөвлөгөө,

тайлан, хэрэгжүүлж буй төсвийн төсөл, санхүүгийн ил тод байдал, худалдан авах ажиллагааны ил тод байдал, нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл гээд бүх талын мэдээллийг шинэчлэн байршуулдаг. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д байгууллагын “...шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг .... төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу жил бүр манай байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, түүний дотор шилэн дансны үйл ажиллагаанд аудитын шалгалт хийж байгаа. Аудитын дүгнэлтээр дээрх үйл ажиллагаанд ямар нэг зөрчил дутагдал заагдаагүй, зохих журмын дагуу хөтөлж байгааг дүгнэсэн байдаг. Шилэн дансны мэдээлэлтэй сонирхсон хэн боловч танилцах бүрэн боломжтой байгаа. Иймд Олон нийтийн зөвлөлөөс байгууллагын шилэн дансны мэдээлэлтэй холбогдуулан үндэслэлгүйгээр АТГ хууль хэрэгжүүлэхгүй, зөрчиж байна гэсэн мэдээлэл тарааж байгаад харамсч байна.

**-ОНЗ-ийн дарга Г.Баасан АТГ ил тод бус, хаалттай, хүнд суртал ихтэй газар гэж хэлээд байгаа шүү дээ?**

-Ил тод бус, хаалттай гэдгийг Г.Баасан дарга юугаар яаж дүгнэж байгаа нь сонин байна. Хуулиар үзүүлж танилцуулж болохгүй хориглосон асуудлыг өөрт нь үзүүлээгүй, танилцуулаагүй гээд ингэж дүгнэж байгаа бол өрөөсгөл дүгнэлт болох байх. ОНЗ-ийн даргаар томилогдож ирээд тавьсан хүсэлтийнх нь дагуу байгууллагын иргэдийг хүлээн авч уулзаж уулзалтын өрөөг өөрт нь албаны өрөө болгон тохижуулан өгч, ОНЗ-ийн дарга, гишүүдийг байгууллагын үйл ажиллагаа, хэлтэс албадын чиг үүрэг, хэрэгжүүлж буй ажилтай нэг бүрчлэн танилцуулан, албан хаагчидтай уулзуулж, хүссэн мэдээллүүдийг нь гаргуулан өгч, үндсэндээ бүх талын

ажиллах боломж бололцоог нь бүрдүүлсэн. Хүссэн мэдээллийг нь бичгээр хуулийн хүрээнд, хугацаанд нь шуурхай гарган өгч байгаа. Газрын удирдлагатай уулзах хүсэлтийг нь хүлээн авч, 3 удаагийн уулзалт хийсэн. Иргэдтэй уулзахад ямар нэгэн хориг байхгүй, чөлөөтэй уулзаж байгаа. Иргэдээс энэ талаар манайд ямар нэгэн гомдол гаргасан зүйл байхгүй. Бодит байдал ийм л байгаа.

**-АТГ-ын даргатай жирийн иргэн уулзахын тулд дааж давшгүй олон хүнд сурталтай тулгардаг, дарга нь өрөөгөө нууцын зэрэглэлд оруулсан, ОНЗ-ийн гишүүд ч нэвтрэх боломжгүй гэх мэдээлэл байдаг. Үүнд хариулт өгөх үү?**

-АТГ-ын дарга, дэд дарга болон бусад хэлтэс, албадын дарга нар иргэд, олон нийтийг шаардлагатай тохиолдолд хүлээж авах дотоод журамтай, тогтсон өдөртэй. АТГ анх байгуулагдсан цагаас энэ журам үйлчилж байгаа. Яг хэн гэдэг иргэнийг хүлээж аваагүй вэ гэдэг талаар мөн л тодорхой нэр устай, цаг минуттай нь яривал ажилд тустай байна.

АТГ-ын дарга албан өрөөгөө нууцын зэрэглэлд оруулах ямар ч боломжгүй. Тэгээд ч нууцын зэрэглэл гэдэг бол огт өөр ойлголт. ОНЗ-ийн гишүүд АТГ-ын даргын өрөөнд орж, газрын дарга тэднийг албан өрөөндөө хүлээн авч уулзсан. Тэр өдөр хийгдсэн мөрдөн шалгах ажиллагааны улмаас газрын даргад ажил танилцуулах мөрдөгч, гүйцэтгэх ажилтнууд олон байсан. Энэ шалтгаанаар ОНЗ-ийн гишүүдийг жаахан хүлээлгэсэн тал бий, урьдчилаад уулзах өдөр, цагийн мэдээллээ ирүүлсэн байсан бол бусад ажилтай давхцаж хүлээх асуудал гаргахааргүй байсан. Тэгээд өрөөндөө хүлээн авч уулзсан, өрөөгөө танилцуулсан, асуудлаа ярилцсан. ОНЗ-ийн гишүүд гарахдаа байдаг л нэг ажлын өрөө байна гэж хэлээд гарсан. Үүнийг мушгин гуйвуулж хэвлэлд ярьсанд харамсч байна. Ер нь бол өдөр болгон ОНЗ-ийн дарга, гишүүдийг хүлээн авч уулзаад байх цаг зав, ажлын бололцоо байхгүй, хийж хэрэгжүүлэх шийдвэрлэх ажил их байдаг. ОНЗ-ийн гишүүдийг анх хүлээн авч уулзахдаа мөрдөгч, гүйцэтгэх ажилтнууд болон мөрдөн байцаалтын ажиллагаанд хамаарах өрөө танхимд орох шаардлагагүй гэдгийг АТГ-ын дарга хэлсэн. АТГ-ын байр бол хуулийн дагуу төрийн тусгай хамгаалалтад байдаг, хараат бус байгууллагын хувьд байгууллагад нэвтрэхэд дотооддоо дагаж мөрдөх журамтай. Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, Тамгын хэлтсийн болон Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн албан хаагчид ч мөрдөгч, гүйцэтгэх ажилтнуудын өрөөнд дуртай үедээ ороод байдаггүй.

**-Шуурхай хяналт шалгалт явуулахаас зайлсхийдэг, үүнээс болж гомдол гаргагч нарыг албан тушаалтнууд дарамталж байна гэсэн. Энэ талаар?**

-Яг ямар гомдол, мэдээллийн тухайд ярьж байна вэ. Түүнийгээ бидэнд хэлчих хэрэгтэй юм л даа. Баримттай, үндэслэлтэй ярихыг л хүсч байна. АТГ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол, мэдээллийг 5 хоногийн дотор хянан шийдвэрлэдэг. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хэрхэн хянаж шийдвэрлэж байгааг прокурор хянадаг. Энэ дунд хийдэл, завхрал үүсгэх ямар ч боломжгүй. Манай үйл ажиллагаатай танилцаж, мөрдөгч нартай уулзах явцдаа Г.Баасан дарга болон гишүүд нь энэ талын ойлголт, мэдээллийг хангалттай авсан л байх. Гэмт хэргийн шинжгүй ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль, холбогдох бусад журмын дагуу 30-60 хоногийн хугацаанд хянан шийдвэрлэж байна.

**-АТГ улс төрийн зарим бүлэглэлд үйлчилдэг гэж олон хүн шүүмжилдэг болсон. Улстөрчдийн гар хөл болж, их хэлмэгдүүлэлт хийдэг газар нь АТГ болсон гэдэг. Үүнд та ямар тайлбар өгөх вэ?**

-АТГ-ыг улс төрийн хүчнүүдийн ч гэдэг юм уу бүлэглэлүүдийн гар хөл болсон мэтээр чичилдэг. Үнэн хэрэгтээ АТГ өөрөө улс төрийн хүчнүүдийн, бүлэглэлүүдийн бохир явуулгад маш их өртөж байнга хараалгадаг. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт нэр холбогдсон тодорхой хүн, хүчний зүгээс АТГ руу чиглэсэн дайралт өргөн хүрээтэй ирдэг. Тэдэнд мэдээж өөрсдийг нь шалгаж байгаа АТГ таалагдахгүй шүү дээ. Шалгагдаж байгаа улстөрч болгон хэвлэлээр өөрийг нь улс төрийн зорилгоор шалгаж байна гэж мэдэгддэг. Тэдэнд эрх мэдэл байна, халдашгүй дархан эрх байна, нэр нөлөө байна, мөнгө байна, хэвлэл байна, мэдээллийн хэрэгсэл байна, өмгөөлөгч нар байна. Тэдний өөдөөс хуулиа барьсан АТГ ганцаараа л байна гэхэд болно.

Иймээс л бид Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлуулж, улсын хэмжээнд төрийн бүх байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтийн хяналтад өгсөн хэрэг. Нэг, хоёр жилийн дараа энэ ажлын нааштай үр дүн гарч эхэлнэ.

**-АТГ байгуулагдаад арван жил болсон. Энэ хугацаанд та бүхний шалгасан нийт хэргээс ердөө л 127 хэргийг шүүхээр шийдсэн гэсэн. Үүнийг амжилт гэх үү, үр дүн гэх үү. АТГ-ын төсөв, хүнд суртал нэмэгдэх тусам авлигын индекс бүх үзүүлэлтээр ухарсаар байгаа. Бүр АТГ-ынхан авлигын индекст орсон тоог нааш цааш нь ухраадаг гээд байгаа шүү дээ?**

-АТГ-ын ажлын үр дүнг хэмжье гэвэл дан ганц шүүхээр шийдэгдсэн хэргийн тоог биш харин АТГ-ын тухайн жилд шалгаж

прокурорын хяналтад шилжүүлсэн, мөн шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн хэргийн тоог харах ёстой болов уу. Энэ тооноос харахад сар болгон авлига албан тушаалын нэг хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж байсан байх нь.

АТГ-аас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжоор олгогдсон эрх мэдлийн хүрээнд, хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн хэргийн тоо, чанар, хүрээ, далайцыг жил тутмаар нь гаргаж үзэх хэрэгтэй. АТГ-ын шалгасан эрүүгийн хэрэг нэг бүрийг прокурор хянадаг. Хяналтын шатанд шийдвэр янз бүр гардаг. Дараа нь шүүхийн шатанд хэлэлцдэг. Тэнд мөн шийдвэр харилцан адилгүй. Энэ бол прокурор, шүүгчийн бүрэн эрх хэмжээний асуудал. Тиймээс дан ганц шүүхээр шийдэгдсэн хэргийн тоогоор АТГ-ын ажлын үр дүнг дүгнэх боломжгүй. Нийгмийн хөгжил дэвшил, эрх зүйн орчин ижил бүхий гадаад улсуудын тоо баримттай үүнийг бас харьцуулаад үзэх хэрэгтэй болов уу. Манай статистик мэдээгээр 200 орчим хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн байдаг юм билээ.

Авлигын индекс өслөө, буурлаа гэдэг мэдээллийг АТГ-г шууд хамаатуулж ойлгох буруу ойлголт нийгэмд байдаг. Нийгэмд байдаг ч юу байх вэ, зориуд тэгж ойлгуулахыг хүсдэг хүмүүс бий. Нөгөө л хэрэгт холбогдож АТГ-ын хаалга үүдээр орж, гарсан хүмүүсийн тараасан цуу яриа шүү дээ. Авлигын индекс гэдэг бол олон улсын “Транспарэнси Интернэшнл” гэдэг байгууллагаас дэлхийн 200 гаруй улс орныг хамруулан улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт мэргэшсэн тусгай шинжээчдийг оролцуулан жил бүр 8-9 үзүүлэлтээр дүгнэж байр эзлүүлдэг ажил. Тэр 8-9 үзүүлэлт нь бүгд тухайн улсын төр, засгийн бодлого, шийдвэр, үйл ажиллагаа, өндөр албан тушаалтнуудынх нь авлигатай тэмцэх хүсэл зориг, төрийн албан хаагчдынх нь ёс зүйд хийсэн үнэлэлт, дүгнэлт байдаг юм.

Тухайлбал, 2015 онд УИХ Өршөөлийн хууль, Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль батлахад манай улсын авлигын индекс тэр жил 72-оос 87 болж 15 байр ухарсан. Энэ хуулиар авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдон шийтгэгдсэн болон шалгагдаж байгаа хүмүүсийг өршөөсөн. Тэгэхээр Монгол Улсын тухайн үеийн төр, засгийн бодлого, шийдвэрийг олон улсын шинжээчид ингэж үнэлсэн явдал. Түүнээс тэр жилдээ АТГ нь сайн ажиллаад, энэ жилдээ муу ажилласан гэдэг үнэлгээ, дүгнэлт биш юм л даа. Авлигын төсөөллийн индексийг жил бүр тус тусдаа бие даан хийсэн 13 төрлийн судалгааны үр дүнг нэгтгэн гаргадаг.

## 3.БААСАННЯМ: АТГ гэдэг дайсан илрүүлчихсэн, түүнтэй тэмцье гээд байгааг ойлгохгүй байна

**Төгсгөл. Түрүүч нь IV, V нүүрт**

-АТГ нь арван жилийн хугацаанд хүлээн авсан ХОМ-т чанарын задлан шинжилгээ огт хийж байгаагүй тул одоо болтол төрд ажиллангаа үндэслэлгүй хөрөнгөжсөн “төрөөс төрсөн тэрбумтан” нэг ч хүнийг тогтоож чадаагүй байгаа гэсэн. Энэ үнэн юм уу?

-Хөрөнгө орлогын мэдүүлэгт огт дүн шинжилгээ хийж байгаагүй гэж хэлж болохгүй л дээ. Энэ чинь манай Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн хийдэг үндсэн ажлуудын нэг нь. Нийтэд тэр болгон шууд зарлаад байж болдоггүй ажлуудын хүрээ энд бас хамаарч л байдаг. Жишээ нь та бүхэн мэдэж байгаа. Татварын ерөнхий газрын удирдах зарим албан тушаалтнуудын хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн. Тэр хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид хэдий хэмжээний хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудлаар шүүхээр шийдвэрлэгдсэн байдаг билээ, эргээд нэг харчих хэрэгтэй л байх. Энэ хэргийг анх хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтаар л үндэс суурийг нь гаргаж ирж байсан. Тэглээ гээд ийм зүйлийг олон нийтэд тэр болгон мэдээлээд байж болдоггүй, зохистой ч юм биш.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалтын хүрээнд Авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн, мөн хөрөнгө, орлогоо зөрчилтэй мэдүүлсэн нийт 1260 албан тушаалтанд сахилгын шийтгэл тооцуулсан дүн байдаг. Авлигатай тэмцэх газар хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд өөрөө шууд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт байхгүй, хариуцлага тооцуулах, зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар тухайн байгууллагын удирдах албан тушаалтанд албан бичгээр шаардлага хүргүүлж, хяналт тавьж ажилладаг.

-АТГ иргэдээс өргөдөл, гомдол, мэдээлэл авахдаа хойрго ханддаг, зарим мэдээллийг хүлээж авдаггүй, иргэдэд айдас үүсгэдэг, дарамталдаг, ноцтой хэргийн гэрчийг хамгаалдаггүй гэсэн дүгнэлт хийсэн байна лээ.

-Иргэдийн өргөдөл, гомдол, мэдээллийг АТГ бүх сувгаар нээлттэй хүлээн авдаг талаар дээр дурдсан. Иргэд ямар нэгэн айдас, дарамтгүйгээр гомдол, мэдээллээ өгдөг. Биеэр ирж өгдөг, бичгээр өгдөг. Цахим шуудангаар ирүүлдэг. Утсаар бас гомдол, мэдээллээ өгдөг. Аль ч тохиолдолд бид өргөдөл,

гомдол, мэдээллийг шуурхай хүлээн авч, бүртгэж, тусгай програмд оруулж, холбогдох хэлтэс, албанд нь шилжүүлэн, хянан шалгаж шийдвэрлэдэг. Энэ бол манай байгууллагад бүхэл бүтэн тогтолцоо болж тогтсон нэг томоохон механизм. Ямар нэгэн хойрго хандсан, хүлээж аваагүй, айдас үүсгэсэн, дарамталсан асуудал байгаа бол тодорхой баримттай, нэр устай, цаг хугацаатай нь хэлэх хэрэгтэй. Гомдол мэдээллийг хянан шалгах бүхий л ажиллагаа прокурорын хяналттай явагддаг, шалгах явцдаа ямар нэгэн хууль зөрчсөн үйлдэл гаргасан тохиолдолд мөрдөн шалгах хэлтсийн даргад болон прокурорт гомдол хүсэлтээ гаргаад шийдвэрлүүлэх бүрэн боломжтой, хохирогч, холбогдогч бүгд л өмгөөлөгчтэй байцаан шийтгэх ажиллагаанд оролцдог болохоор айлгах, дарамтлах ямар ч боломжгүй гэдгийг одоо хэн ч мэддэг болсон доо.

Гэхдээ энд нэг тодотгох зүйл байна. АТГ-аас олон нийт дуулиантай гэмт хэргийн талаарх мэдээллийг илүү сонирхдог. Хэвлэл мэдээллийн байгууллага болохоор шалгагдаж байгаа хэрэг, хэрэгт холбогдсон хүмүүсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөнгүй, хуйвалдаад дараад байна, ил тод биш хаалттай байна гэж буруутгадаг. Гэтэл энэ талын мэдээллийг АТГ тэр бүр өгөх боломжгүй. Энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д зааснаар хориотой. Шалгагдаж байгаа хэргийн талаарх мэдээллийг прокурорын зөвшөөрөлгүйгээр өгөх эрхгүй. Бусад улс орнуудын практикаас харж байхад авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдогчдын талаар тодорхой мэдээлдэг юм билээ. Бидний хувьд авлигын гэмт хэргийн талаар олон нийтэд мэдээлэл өгмөөр байдаг боловч дээрхи хуулийн хориглолтоос болоод мэдээлэх боломжгүй байдаг юм.

-АТГ-ын дарга Х.Энхжаргалын талаар сүүлийн үед таагүй мэдээлэл цацагдаад байгаа. Түүний хуулийн байгууллагад ажилласан түүх нь бохир, хувийн ашиг сонирхолтой, улс төрийн бүлэглэлд хамаардаг, албан хаагчидтайгаа дарангуйллын хэлбэрээр харьцдаг, ажлаа таваас дээш хоногоор тасалдаг гэх мэдээлэл гарсан?

-АТГ-ын даргын хувь хүн рүү чиглэсэн мэдээлэл учраас би өмнөөс нь тайлбар хэлэх нь утгагүй. Хамтран ажиллаж байгаагийн хувьд ажил таслах нь битгий хэл ээлжийн

амралтаа ч эдэлж чадахгүй ирэн очин ажлаа хийж л байсан гэдгийг хэлэх хэрэгтэй байх. Ер нь АТГ-ын дарга гэлтгүй төрд алба хааж байгаа төрийн албан хаагч бүр энэ мэт болсон болоогүй сөрөг мэдээллүүдийг элдэв тайлбаргүйгээр дааж, давах ёстой ч юм шиг. Худал ташаа мэдээлэл болгонд төрийн алба, албан хаагч хариу тайлбар мэдээлэл гаргаад байх нь зохимжгүй гэж би хувьдаа үздэг. Гэвч хувь хүний нэр төрд халдсан илт худал ташаа мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зорнуудаар тарааж байгаа үйлдлээ хэзээ зогсоох юм бол доо.

Х.Энхжаргал АТГ-ын дарга болсноос хойших хугацаанд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр УИХ-аар батлагдсан. Авлигатай тэмцэх 6 жилийн хугацаатай бодлого, стратеги үндэсний хэмжээнд хэрэгжиж эхэлсэн. Стратегиа дагаад түүнийг хэрэгжүүлэх төсөв сая бас батлагдлаа. Үндэсний хөтөлбөрийг үрдүнтэй хэрэгжүүлэх хүрээнд АТГ шинэ зохион байгуулалтад орж төрийн бүх шатны байгууллагад авлигын эрсдэлийг тогтоож ажилласан. Хөтөлбөр хэрэгжсэн нэг жилийн хугацаанд төв болон орон нутгийн төрийн байгууллагуудад хоёр ч удаа очиж ажиллалаа. Төрийн байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагааг иргэд, олон нийтийн хяналтад өглөө. “Олон нийтийн төв”-ийг байгуулж, үүнийгээ цаашид Зүүн өмнөд Азийн хэмжээний олон улсын сургалтын төв болгохоор Авлигын эсрэг олон улсын академи болон бусад гадаадын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд харьцангуй богино хугацаанд нэлээд олон ажлыг амжууллаа.

Уг нь бол АТГ-ын дэргэдэх ОНЗ нь АТГ-тай хүчээ нийлүүлээд авлигын эсрэг тэмцэх, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр зөвлөмж өгөөд, дэмжлэг үзүүлэх ёстой юм шүү дээ, хуулиараа бол. Бидний дайсан бол зөвхөн авлига юм. Гэтэл АТГ гэдэг дайсан илрүүлчихсэн, түүнтэйгээ тэмцье гээд байгааг ерөөсөө ойлгохгүй байна. Ажил хэрэгчээр хандаж, хойшдын ажил албанд хэрэг болох санал, шүүмжлэл тавьж байгаа бол бид хүлээж авна, ямар ч тайлбар хэлэх шаардлага байхгүй.

**Ярилсан Э.ХҮРЭЛБААТАР**



## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ШАЛГАЛТЫН МӨРӨӨР

**Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгүүд 13 яам, 27 агентлагт ажиллаж, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцсан билээ. Авлигатай тэмцэх газар төрийн бүх шатны байгууллагуудад хийсэн шалгалтын дүнгээ тухайн байгууллагын удирдах албан тушаалтнуудыг оролцуулан хэлэлцүүлсэн юм. Уг хэлэлцүүлгийн үеэр илэрсэн зөрчил, дутагдлыг танилцуулж, тэдгээрийг арилгах, засах, цаашид дахин гаргуулахгүй байх чиглэлээр санал, зөвлөмж өгсөн бөгөөд Авлигатай тэмцэх газрын шалган туслах ажлын мөрөөр зарим төрийн байгууллагууд тодорхой ажил зохион байгуулаад эхэлжээ.**

### Цаашид төрийн албан хаагчийг шинжээчээр томилохгүй

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг Уул уурхайн яам болон түүний харьяа агентлагуудын авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцсан дүнгээ өнгөрсөн сард танилцуулсан.

Тус яам болон Ашигт малтмал газрын тосны газрын 19 албан хаагч ажил үүргийнхээ хажуугаар шинжээчийн үүргийг давхар гүйцэтгэдэг. Ажлын хөлсөнд 3-25 сая төгрөг авсан нь ил болсон. Иймд Авлигатай тэмцэх газар “Эрхэлж буй ажлынхаа хүрээнд шинжээчээр оролцож, түүнээсээ орлого олохыг зөвшөөрсөн журам үйлчилж байгаа нь авлигын эрсдэлтэй. Төрийн албан хаагч хуулиар зөвшөөрснөөс өөр давхар ажил эрхлэхгүй байх хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн. Төрийн яамны бодлогыг хэрэгжүүлдэг мэргэжилтнүүд үр дүн, гүйцэтгэл шаардах ёстой аж ахуйн нэгжүүдээсээ шинжээчийн ажлын хөлс нэрээр төлбөр авах нь илт ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл” гэж дүгнэсэн юм.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд болсон хэвлэлийн бага хурлын үеэр дээрх дүгнэлтийн талаар тодруулж, 19



албан хаагчид хариуцлага тооцсон эсэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогтоос лавлахад “Ашигт малтмалын тухай хуульд хайгуулын ажлын болон нөөцийн тайлан, ТЭЗҮ-г бэлтгэхдээ

заавал хөндлөнгийн шинжээч ажиллуулна. Шинжээч нь мэргэшсэн зөвлөх байна гэж заасан. Энэ дагуу Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийг байгуулан, энэ зөвлөлд яамны зарим мэргэжилтэн багтан ажилладаг. 19 албан хаагчид хариуцлага тооцоогүй. Цаашид төрийн албан хаагчийг шинжээчээр томилохгүй. Уул уурхайн салбарын мэргэшсэн шинжээч, зөвлөх манай салбарт дутмаг тул шинжээчээр давхар ажилладаг” гэж хариулав.

Эх сурвалж: [www.gogo.mn](http://www.gogo.mn)

### Төрийн сангийн зээлээр гадаад улсад суралцсан иргэдийн нэрсийг зарлалаа

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд ажиллах үеэрээ Боловсролын зээлийн сангийн зээлээр гадаад улсад суралцсан иргэдийн судалгаатай нарийвчлан танилцсан юм. Сургалтын төрийн сан /хуучин нэрээр/-гаас зээл авч гадаад улсад суралцсан боловч сургуулиа төгсөөд бүртгүүлээгүй, алга болсон иргэдийн судалгааг илүү нарийвчлан гаргаж, буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэж, нийтэд ил тод мэдээлэх шаардлагатай гэж Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг дүгнэж, тодорхой үүрэг өгсөн билээ.


Үүний дагуу Боловсролын зээлийн сангаас өөрийн албан ёсны цахим хуудсанд 1997-2012 оны хооронд төрийн сангийн зээлээр гадаад улсад суралцсан ч гэрээний үүргээ биелүүлээгүй 393 иргэний нэрсийг зарласан бөгөөд сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадын их, дээд сургуулийн магистрантур, докторантурт суралцсан иргэд Боловсролын зээлийн сангийн холбогдох мэргэжилтэнтэй 2017 оны 11 дүгээр сарын 7-ноос 12 дугаар сарын 8-ны хооронд ирж уулзах, заасан хугацаанд ирж уулзаагүй тохиолдолд дараагийн арга

хэмжээ авахыг анхааруулсан байна.

### Боловсролын салбарын удирдах ажилтны ёс зүйн дүрмийг батлахаар болов

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу бүх шатны сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг батлахаар болов.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Авлигатай тэмцэх газраас томилогдсон ажлын хэсэг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд ажиллах үеэрээ тус салбарын эрх зүйн орчин, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын өнөөгийн нөхцөл байдлыг судалж үзсэн юм. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 41 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм”-д Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсролын үйлчилгээ эрхэлж байгаа төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, туслах багш захирагдана гэсэн байна. Энэ заалтаас



үзэхэд ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежер, цэцэрлэгийн эрхлэгч нарт дээрх ёс зүйн дүрэм хамаардаггүй бөгөөд суралцагчдаас хандив, төлбөр, хураамж авсан зэрэг ёс зүйн бусад зөрчлөөр хариуцлага тооцох боломжгүй байгааг Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг дүгнэсэн.

Тиймээс “Боловсролын удирдах ажилтан, албан хаагч, багшийн ёс зүйн код, хариуцлагын тогтолцооны механизм”-ыг боловсруулах, батлуулах, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг боловсруулах, Ёс зүйн дүрэмд сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтны /захирал, эрхлэгч/ хүлээх ёс зүйн үүрэг хариуцлагыг оруулах нь зүйтэй гэж Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгээс Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны удирдах албан тушаалтнуудад зөвлөсөн юм. Энэ дагуу тус яамнаас бүх шатны сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг батлахаар ажиллаж эхэллээ.

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 2017 ОНЫ III УЛИРАЛД 118 ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ШИЙДВЭРЛЭВ

-АТГ-г ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн дүр зураглал-

*Авлигатай тэмцэх газар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авдаг бөгөөд тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар сар бүр дотооддоо дүн шинжилгээ хийдэг. Ийнхүү дүн шинжилгээ хийх нь энэ чиглэлийн ажлын үр дүнгээ тооцох, цаашид улам сайжруулахад анхаарах асуудлаа тодорхойлоход ач тустай ажээ. Энэ удаа 2017 оны III улиралд хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх дүн шинжилгээний мэдээллийг нэг өгүүлбэрээр танилцуулъя.*

- 2017 оны III улиралд АТГ нийт 181 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авчээ.
- Өргөдөл, гомдол, мэдээллийн дийлэнхийг буюу 146-г нь иргэд биеэр ирж өгчээ.
- Улаанбаатар хотоос 126 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн нь хамгийн олон байна.
- Төв аймгаас 9, Баянхонгор аймгаас 5, Ховд аймгаас 4, Дорнод, Хэнтий, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь, Архангай, Говь-Алтай аймгаас тус бүр 3, Сүхбаатар, Дундговь, Орхон, Завхан, Баян-Өлгий аймгаас тус бүр 2, Өвөрхангай, Булган, Хөвсгөл аймгаас тус бүр 1 өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн байв.
- Увс, Дархан-Уул аймгаас өргөдөл, гомдол, мэдээлэл ирээгүй байна.
- 124 өргөдөл, гомдол, мэдээллийн агуулга нь гэмт хэргийн шинжтэй, 54 нь ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой байжээ. Төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой 3 мэдээлэл байв.
- Цагдаа, боловсрол, нутгийн удирдлага, барилгын салбар болон байгууллагатай холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл 2017 оны III улиралд давамгайлжээ. Нийт өргөдөл, гомдол, мэдээллийн 48 нь цагдаа, 20 хувь нь боловсролын салбарт хамаарч байна.
- Өргөдөл, гомдол, мэдээлэлд холбогдсон албан тушаалтнуудын 29 нь төрийн тусгай албаны, 24 нь төрийн захиргааны, 14 нь төрийн үйлчилгээний, 14 төрийн улс төрийн албан тушаалтан, 4 нь төрийн оролцоотой хуулийн этгээдийн албан хаагч, 3 нь төрийн бус байгууллагын ажилтан зэрэг байна.
- Албан тушаалаа урвуулсан, хэтрүүлсэн гэх гомдол 54 буюу хамгийн олон байв.
- АТГ иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 2017 оны III улиралд хүлээн авсан 181 өргөдөл, гомдол, мэдээллийн 118-ыг нь шийдвэрлэсэн байна.
- Гэмт хэргийн шинжтэй 22 гомдолд эрүүгийн хэрэг үүсгэсэн бол 1 өргөдөл, гомдол, мэдээллийн зөрчлийг тогтоож шийдвэрлэжээ. Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээллийн 9-д нь зөрчил илрээгүй тул хаасан байна.

## АСУУВАЛ ХАРИУЛЪЯ

### Олон нийтийн дэд зөвлөл нь Олон нийтийн зөвлөлтэй хамааралгүй

-АТГ-ын дэргэд Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдсон Олон нийтийн зөвлөл ажиллаж байгаа юм байна. Сүүлийн үед АТГ-ын албан хаагчид орон нутагт томилолтоор ажиллаж явахдаа аймгуудад Олон нийтийн дэд зөвлөл байгуулж байгаа гэж мэдээлэгдэж байна. Олон нийтийн зөвлөлийн салбарууд 21 аймагт байгуулагдаж байгаа гэж ойлгож болох уу?

*Нийслэлийн Баянзүрх дүүргийн иргэн Н.Пүрэвдорж*

-Энэ бол 2 өөр ойлголт. Авлигатай тэмцэх газрын дэргэд орон тооны бус Олон нийтийн зөвлөл ажиллахаар Авлигын эсрэг хуульд заасан. Тус хуулийн 27 дугаар зүйлд Олон нийтийн зөвлөлийн талаар заасан нь бий. Олон нийтийн зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийг төлөөлөх 15 иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар томилдог. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл нь авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд зөвлөмж өгөх зорилготой юм.

Харин аймаг бүрт байгуулагдаж байгаа Олон нийтийн дэд зөвлөл нь дээр дурдсан одоогийн Г.Баасан даргатай Олон нийтийн зөвлөлд огт хамааралгүй. Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ажил юм. УИХ-аар 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт “яам, агентлаг, орон нутагт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд ажиллах авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөл”-ийг байгуулан ажиллуулахаар тусгасан. Энэ зөвлөл авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн идэвх санаачилгыг өрнүүлэх, хөхиүлэн дэмжих, төрийн байгууллагын үйл ажиллагаа, албан тушаалтны ёс зүйд хяналт тавих гол зорилготой.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.4.15-д “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулна” гэж заасан бөгөөд энэ хүрээнд “Олон нийтийн дэд зөвлөл”-ийг аймаг, нийслэл, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд болон салбарын хэмжээнд байгуулах, мэргэжил-арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг жигдрүүлж хэвшүүлэхээр манай албан хаагчид ажиллаж байна.

Авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Олон нийтийн дэд зөвлөл нь 3 гишүүнтэй ажиллана. Тэдгээр нь бүгд иргэн байна. Нэг иргэн нь аймаг, яам, агентлагийн нээлттэй, ил тод байдлыг хянана. Хууль тогтоомж зөрчсөн болон хүнд суртал, чирэгдэл учруулсан дүрэм, журам, шийдвэрийг хянах, төрийн байгууллага, нийтийн албан тушаалтан иргэдийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулж буй эсхийг хянана. Хоёр дахь иргэн нь Шилэн дансны хуулийн хэрэгжилт, тухайн төрийн байгууллагын төсөв, санхүү, төсвийн орлого, зарцуулалт, хандив, зээл тусламж, түүний хуваарилалт, төсөл хөтөлбөр, худалдан авах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гарч байгаа эсэхэд хяналт тавих юм. Харин гурав дахь иргэн нь нийтийн албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлсэн эсхийг хянаж зөрчил илэрсэн тохиолдолд манайд мэдэгдэж шалгуулж байх учиртай. Тэд хянаж шалгах эрх эдлэхгүй. Аймаг, яам, агентлаг бүрт буюу төрийн байгууллагуудад иргэд, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй 3 иргэн ажиллана гэсэн үг.

*Авлигатай тэмцэх газрын Хэвлэл, олон нийттэй харилцах  
ажилтан, комиссар Т.Мөнхтунгалаг*

Эхийг бэлтгэсэн: Т.Мөнхтунгалаг  
Гэрэл зургийг Б.Барбаатар, А.Санжаа

Мэдээллийн хуудасны талаарх санал, сэтгэгдлийг  
70112463 дугаарын утсаар хүлээн авна.